

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2011 оны 10 дугаар
сарын 4-ний өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Хэрэгцээний халуун усыг халаасан дулааны төлбөрийг тогтоох тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд ус, дулаан дамжуулах төвөөс хэрэгцээний халуун усаар хангагдаж, орон сууцны байр болон өргөтгөлд аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хэрэгцээний халуун усны зарцуулалтын хэмжүүргүй хэрэглэгчдийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг дараах байдлаар тооцсугай. Үүнд:

1) Кафе, цайны газрын хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0.15 Гкал/сар (0.63 ГДж/сар)-аар тооцон суудлын тоогоор үржүүлж;

2) Үсчин, гоо сайхны газрын хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 1.93 Гкал/сар (8.08 ГДж/сар)-аар тооцон суудлын тоогоор үржүүлж;

3) Хүнсний дэлгүүр, компьютер тоглоомын газрын хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 2.45 Гкал/сар (10.26 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

4) Сауны хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 2.06 Гкал/сар (8.62 ГДж/сар)-аар тооцон шүршүүр, тосгуурын тоогоор үржүүлж;

5) Эмийн сангийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 2.07 Гкал/сар (8.67 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

6) Зочид буудлын шүршүүр, тосгуур бүхий өрөөний 1 оронд ногдох хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0.28 Гкал (1.17 ГДж)-аар тооцон орны тоогоор үржүүлж;

7) Амбулаторийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0.68 Гкал (2.85 ГДж)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

8) Эмнэлэгийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааныг 0.264 Гкал (1.11 ГДж)-аар тооцон орны тоогоор үржүүлж;

9) Оёдол, цэцгийн дэлгүүр, кино прокат, гар урлалын зориулалттай байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 0.055 Гкал/сар (0.23 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

10) Гурилын цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 0.27 Гкал/сар (1.13 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

11) Ундааны цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 0.66 Гкал/сар (2.76 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

12) Шил угаах цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 1.3 Гкал/сар (5.44 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

13) Бууз, баншны цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 0.16 Гкал/сар (0.67 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

14) Сургууль, цэцэрлэгийн зориулалттай байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 1.0 Гкал/сар (4.19 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

15) Зайрмагны цехийн зориулалттай байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 1.0 Гкал/сар (4.19 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

16) Албан контор, хими цэвэрлэгээний хүлээн авах цэг, барьцаалан зээлдүүлэх, бичиг баримт хувилж олшруулах үйл ажиллагаа явуулж байгаа байрны хэрэгцээний халуун ус халаасан дулааныг 0.11 Гкал/сар (0.46 ГДж/сар)-аар тооцон тосгуурын тоогоор үржүүлж;

2. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд ус, дулаан дамжуулах төвөөс хэрэгцээний халуун усаар хангагдаж буй хэрэглэгчдийн хэрэглэсэн хэрэгцээний 1 м^3 халуун усыг холбогдох дүрэм (Барилгын норм ба дүрэм, тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм) болон гэрээнд заасны дагуу халаасан дулааны төлбөрийг усны зарцуулалтаар (хэмжүүрийн заалтаар гарсан) тооцох тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

3. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд ус, дулаан дамжуулах төвөөс хэрэгцээний халуун усаар хангагдаж, орон сууцны байр болон өргөтгөлд аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа хэрэгцээний халуун усны зарцуулалтын хэмжүүргүй хэрэглэгчдийн хэрэгцээний халуун усыг халаасан 1 Гкал (1 ГДж) дулааныг Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн баталсан тарифаар тооцсугай.

4. Ус, дулаан дамжуулах төвөөс хэрэгцээний халуун усаар хангагдаж байгаа өөрийн тусгайлсан зураг төслөөр баригдсан барилга, объект бүхий хэмжүүргүй хэрэглэгчдийн хэрэгцээний халуун усыг халаасан дулааны төлбөрийг тухайн барилгын зураг төсөлд заасан ачааллыг үндэслэн тооцож байхыг дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын захирал нарт үүрэг болгосугай.

5. Цаашид хэрэглэгчдийн хэрэглэсэн хэрэгцээний халуун усыг халаасан дулааны тоолуурыг шинээр баригдах барилга, байгууламжийн техникийн нөхцөл,

зураг төсөлд тусгаж байхыг, мөн “Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах” аж ахуйн гэрээнд тоолуураар тооцоо хийх хэрэглэгчдийн жагсаалтыг орон сууцны компаниудтай харилцан тохиролцон баталгаажуулж ажиллахыг УБДС ТӨХК /Д.Бямба-Очир/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоолыг 2011 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд /гүйцэтгэх захирал, захирал, дарга нар/-д даалгасугай.

7. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах газрын Тусгай зөвшөөрлийн алба /М.Мөнхтулга/, Үнэ тарифын алба /М.Ганчимэг/-нд тус тус даалгасугай.

8. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн “Хэрэгцээний халуун усыг халаасан дулааны төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” 2008 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 163 дугаар тогтоол, “Ахуйн хэрэгцээний халуун усыг халаасан дулааны төлбөр тооцох тухай” 2005 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 119 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗОХИЦУУЛАГЧДЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Н.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Д.БАССАЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.ЖАМЦАЙ

**УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ХЭРЭГЦЭЭНИЙ ХАЛУУН УС ХАЛААСАН ДУЛААНЫ ТАРИФ**

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Төг/м ³	1,300.00	
2	Айл өрх	Халаалтын улиралд	Төг/м ³	700.00
		Халаалтын бус улиралд	Төг/м ³	1050.00